НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

Дүүргийн газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг тус тус үндэслэн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн газар зохион байгуулалтын 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.
2. Дүүргийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Дүүргийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөг батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг дарга /Х.Болормаа/-д ДААЛГАХ нь:
   - 3.1 Газрын тухай хууль тогтоомжийг баримтлан дүүргийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
   - 3.2 Дүүргийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хагас бүтэн жилээр тайлагнах, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд танилцуулах
4. Дүүргийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн баталж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байхыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА Б. Б.ЭНХБОЛД

1140100044

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 14 дугаар тогтоол

ДҮҮРГИЙН 2021 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Төлөвлөгөөнд тусгах үндэслэл
Нэг. Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил				
1.	Газар чөлөөлөх, нөхөх олговор олгох эрх зүйн орчныг боловсронгуй болгоход саналаа хүргүүлэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.4 дэх заалт;
2.	"Газрын тухай" багц хуульд өөрчлөлт оруулах асуудлаар саналаа хүргүүлэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон дэд бүтцийн болон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаатай холбогдон улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэх, газрын эдийн засгийн үр өгөөж ихээхэн нэмэгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас газрын эрхзүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, эрхзүйн шинэтгэл хийх, газрын нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх зэргээр нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Газрын тухай багц хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүссэн;
3.	Иргэн, хуулийн этгээдээс газар эзэмших, ашиглахтай холбоотой гаргасан хүсэлтийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор ГХГЗЗГ-ын даргын 2008 оны 83 дугаар тушаал "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулан Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалд өөрчлөлт

	олгох журам”-д өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх			оруулах шаардлага үүссэн;
4.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох заалтад өөрчлөлт оруулахад санал хүргүүлэх	НЗДТГ, НГЗБА, НХБХГ, УСУГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан зарим хил нь олон жил суурьшин амьдарч буй иргэдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газартай давхацсан, зарим хэсэгт тогтоолд авах шаардлагагүй газруудыг хамааруулсан зэргээс шалтгаалан тогтоолын хэрэгжилтийг хангах, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учирч, Монгол Улсын Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дэх заалтууд бүрэн хэрэгжиж чадахгүй байгаа тул тогтоолыг өөрчлөх шаардлагатай болсон;
Хоёр. Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил				
5.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахад дүүргийн төлөвлөгөөний саналыг хүргүүлэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө”, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт;
6.	Дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах	НЗДТГ, ЗАА, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Зорилт 2.5, 9.2 дах заалт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4.1 дэх заалт;
7.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Газрын бирж”-ийн цахим систем /www.mle.mn/ -	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 23.2.7 “Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах” дах заалт;

	ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах			Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 152 дугаар тогтоол;
8.	Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг зохион байгуулах	НХБХГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.3.2 дах заалт;
9.	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах	НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт
Гурав. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил				
Хот байгуулалтын чиглэлээр:				
10.	Улаанбаатар хотын хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулгаж дахин барилгажуулах ажлыг талаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх	НХБХГ	I-IV улиралд	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны "Журам батлах тухай" 90 дүгээр тогтоол;
11.	Дүүргийн 5-8 дугаар хороодын нутаг дэвсгэрт авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	НХБХГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол;
12.	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн зуслангийн 2 амны ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахад санал хүргүүлэх	НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I- IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.1.2 дах заалт;
13.	Дүүргийн нутаг дэвсгэрт "Дугуйн зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай газар чөлөөлөлтийн ажлыг гүйцэтгэх	ЗАА, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.20.3 дах заалт;
14.	1-8, 10 дугаар хороодын нутаг дэвсгэрт орон сууцны хороолол дундах автомашины гаражуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг	НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийг хэрэгжүүлэх, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.4 дэх заалт;

	бүрдүүлэх			
15.	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийг хөгжүүлэх гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлэн зохион байгуулах	ХБХГ, НОСДБГ	I-IV улиралд	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 7/29, 12/43, 2019 оны 161, 2020 оны 48 дугаар тогтоол;
Газар зохион байгуулалтын чиглэлээр:				
16.	Дүүрэг, хорооны хилийн цэсийн маргааныг холбогдох дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	НИТХ, НЗДТГ, НГЗБА, ДИТХ, ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, УИХ-ын 1996 оны 24 дүгээр тогтоол;
17.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Дамбадаржаа дэд төвийн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, НХБХГ, АХБ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.2.2 дах заалт;
18.	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламж болон өөрийн хөрөнгөөр дүүргийн нутаг дэвсгэрт баригдах инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн ажлын зураг төслийг хүлээн авч, нөлөөлөлд өртсөн нэгж талбарын суурин судалгааг гарган, санал өгч зөвшилцөх ажлыг зохион байгуулах	НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 56.1 "Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ" дэх заалт;
19.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах	ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн

				захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" дах заалт;
Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил				
20.	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг иргэнд өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах;
21.	Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах			Нийслэлийн пргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол;
Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил				
22.	Дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах	НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дах заалт;
23.	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 56.5 "Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна" дэх заалт;

24.	“Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл”-ийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах асуудлуудыг тухай бүрт нь хэлэлцэж дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэх	ДЗД, ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын Газрын тухай хуулийн 31.3 дахь заалт, 35.3.5 дахь хэсэг
25.	“Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл”-ийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацааг сунгах асуудлуудыг тухай бүрт нь хэлэлцэж дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэх	ДЗД, ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын Газрын тухай хуулийн 37, 38 дугаар зүйл
Зургаа. Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил				
26.	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	ДЗД, ДГЗБА	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;
27.	Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшн /e-gazar/-д хөгжүүлэлт хийж, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх.	ГЗБГЗЗГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоол;
Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийгдэх ажил				
28.	Иргэнд өмчлүүлсэн газарт үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор Монгол Улсын хэмжээнд газрын суурь үнэ болон газрын бүсчлэлийг шинэчлэн тогтоосон;
29.	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллах	ДГЗБА	I-IV улиралд	
30.	Нийслэлийн газрын төлбөрийн орлогын мэдээний бүртгэлийг боловсронгуй болгох, гүйцэтгэлийг хянах, газрын нэгдсэн мэдээллийн системд газрын төлбөрийн мэдээллийн санг нэгтгэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	

ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ								
Д/д	Дүүрэг	Хороо	Газрын байршил	Иргэд-ийн тоо	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1.	Сүхбаатар	11	Алтайн 22-28 дугаар гудамж, Рашаантын 16-20 дугаар гудамж, Зүүн сэлбэ 4-10 дугаар гудамж	1	0.05	Гэр бүлийн хэрэгцээнд	I-IV улиралд	НГЗБА, ДГЗБА
2.		12	Хангайн 1-24 дугээр гудамж	1	0.05			
3.		13	Рашааны 1-16 дугаар гудамж, Ногооны талбайн 1-7 дугаар гудамж, Хангайн 23-24 дугээр гудамж	1	0.05			
4.		14	Хандгайтын 15-43 дугаар гудамж, Ногооны талбайн 1-3 дугаар гудамж	2	0.1			
5.		15	Дамбадаржаагийн 1-24 дугээр гудамж, 21-45 дугаар гудамж, 81-84 дугээр гудамж	5	0.25			
6.		16	Тоосгоны 1-5 дугаар гудамж, Бэлхийн 1-36 дугаар гудамж, Ойчид, Бэлхийн 33-1-ээс 33-7 дугаар гудамж	2	0.1			
7.		17	Дамбадаржаагийн 25-83 дугаар гудамж, АОС, НҮН	5	0.25			
8.		18	Бэлхийн 35-54 дугээр гудамж, Гүнжийн 43-44 дугээр гудамж	28	1.4			
9.		15	Ар хустай	37	1.85			
10.		19	Шарга морьт, Гоодой, Хуурай мухар, Хандгайт, Хандгайтын богино, Санзай, Баянбулаг, Майхан толгой	94	4.7			
11.		20	Бэлх, Бэлхийн цолмон, Бэлхийн хадат, Бэлхийн цуурайт, Бэлхийн мааньт, Бэлхийн даваат, Бэлхийн цээнэ, Сэлх, Сэлбэ	115	5.75			
Дүн				291	14.55			

2.2 Эзэмшүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээ							
д/д	Дүүрэг, хороо	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Иргэний тоо	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
Гэр, орон сууцны хашааны газар							
1.	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо	Далангийн	Гэр бүлийн хэрэгцээний	5	0.3	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
2.	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо	БЗНТ-80 айл, Геологийн 48, Зүүн сэлбийн гудамж, Рашаантын гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	2	0.1	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
3.	Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо	Хангайн гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	3	0.2	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
4.	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо	Ногоон талбайн гудамж, Рашааны гудамж, УИД	Гэр бүлийн хэрэгцээний	30	1.5	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
5.	Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо	Хандгайтын гудамж, Ногооны талбайн гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	5	0.3	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
6.	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо	Дамбадаржаагийн гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	10	0.5	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
7.	Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо	Тоосгоны гудамж, Бэлхийн гудамж, Ойчдын гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	50	3.0	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
8.	Сүхбаатар дүүргийн 17 дугаар хороо	Дамбадаржаагийн гудамж, АОС, НҮН	Гэр бүлийн хэрэгцээний	5	0.3	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
9.	Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороо	Бэлхийн гудамж, Гүнжийн гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	35	2.1	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
Дүн				145	8.3		
Гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар							
10.	Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо	Архустай	Гэр бүлийн хэрэгцээний	40	2.4	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
11.	Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо	Гоодой	Гэр бүлийн хэрэгцээний	80	4.8	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
12.		Шаргаморьт	Гэр бүлийн	180	10.8	I-IV	ДЗД, ДГЗБА

			хэрэгцээний			улиралд	
13.		Хуурай мухар	Гэр бүлийн хэрэгцээний	65	3.9	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
14.		Баянбулаг	Гэр бүлийн хэрэгцээний	32	1.9	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
15.		Майхан толгой	Гэр бүлийн хэрэгцээний	50	3.0	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
16.		Хандгайт	Гэр бүлийн хэрэгцээний	80	4.8	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
17.		Хандгайтын богино	Гэр бүлийн хэрэгцээний	28	1.7	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
18.		Санзай	Гэр бүлийн хэрэгцээний	80	4.8	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
19.	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо	Бэлх	Гэр бүлийн хэрэгцээний	320	19.2	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
20.		Сэлх	Гэр бүлийн хэрэгцээний	250	15.0	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
21.		Сэлбэ	Гэр бүлийн хэрэгцээний	250	15.0	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
Дүн				1455	87.3		
Бусад зориулалтаар							
22.	Сүхбаатар дүүргийн 19-р хороо	Хандгайт	Мод үржүүлэг	1	1.5	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
23	Сүхбаатар дүүргийн 17-р хороо	Япон цогцолборын урд талд	Амины орон сууц	6	0.3	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
Дүн				1607	97.4		

2.3 Ашиглуулах газрын зориулалт, байршил, хэмжээ							
Д/д	Дүүрэг, хороо	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Зориулалт	Иргэний тоо	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
Гэр, орон сууцны хашааны газар							
1.	Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо	Хангайн гудамж	Гэр бүлийн хэрэгцээний	5	0.25	I-IV улиралд	ДЗД, ДГЗБА
Дүн				5	0.25		

2.4 Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд						
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо	Ногоон нуур	Худаг	0.015	I-IV улиралд	СБДЗДТГ, НГЗБА
2.	Сүхбаатар дүүргийн 12,13,14,15,16,17,18,19,20 дугаар	Хорооны нутаг дэвсгэрт	Худаг	0.2	I-IV улиралд	СБДЗДТГ, НГЗБА
3.	Сүхбаатар дүүрэгт	Дүүргийн нутаг дэвсгэрт	Дугуйн сургалтын талбай, дугуйн хөгжлийн төв	0.3	I-IV улиралд	СБДЗДТГ, НГЗБА
4.	Сүхбаатар дүүргийн 9, 11, 12, 13, 14-р хороодын аль нэг нутаг дэвсгэрт	Хорооны нутаг дэвсгэр	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга	0.8	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
5.	Сүхбаатар дүүрэг 11 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолбор барилга	0.2	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
6.	Сүхбаатар дүүрэг 17 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолбор барилга	0.2	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
7.	Сүхбаатар дүүрэг 9-20 дугаар хороодын аль нэг нутаг дэвсгэрт	Хорооны нутаг дэвсгэрт	Төрийн байгууллага	1.0	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
8.	Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Ахмадын асрамжийн төв	0.5	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
Дүн				3.215		

2.5. Авто зам, замын байгууламж						
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Талбай /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Сүхбаатар дүүргийн 10, 11, 12, 13, 14, 15 дугаар хороо	Авто замын ус зайлуулах сувагчлал	0:5	Авто зам	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА

2.	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо	Рашааны 9, 10 дугаар гудамжинд хийгдсэн авто замыг үргэлжлүүлэх	0.224	Авто зам	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
Дүн			0.724			

2.6 Орчны тохижилт, ногоон байгууламж, явган хүний замыг нэмэгдүүлэх						
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.	Сүхбаатар дүүргийн 15, 20 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	Тохижилт	500	I-IV улиралд	ЗАА, СБДЗДТГ
Дүн				500		

2.7 Газрын элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ							
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Газрын нэгдмэл сангийн ангилал	Газрын хэмжээ /га/	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1.	Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо	Хандгайтын зуслан	Ойн сан бүхий газар	1.0	Ойжуулах	II-IV улиралд	НБОГ
Дүн				1.0			

ГУРАВ. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3.1 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууц, барилга байгууламжийг буулган шинэчлэн барилгажуулах						
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Тайлбар
1	Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороо	Орон сууцны 53 дугаар байр	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг	0.05	I-IV улиралд	НХБХГ
2	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо	Орон сууцны 22 дугаар байр, Сэрэлт-22 СӨХ		0.08	I-IV улиралд	НХБХГ
3	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо	Орон сууцны 1, 2, 3, 4, 24 дүгээр байр, Уйлган СӨХ		1.09	I-IV улиралд	НХБХГ
4	Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо	Орон сууцны 5, 25, 27, 28 дугаар байр, Эхлэл-2 СӨХ		0.75	I-IV улиралд	НХБХГ
5	Сүхбаатар дүүргийн 6	Орон сууцны 21 дүгээр байр		0.14	I-IV	НХБХГ

	дугаар хороо		буулган шинээр барих		улиралд	
6	Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо	Орон сууцны 64 дүгээр байр		0.24	I-IV улиралд	НХБХГ
7	Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо	Орон сууцны 40 дугаар байр		0.23	I-IV улиралд	НХБХГ
8	Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо	Нийтийн орон сууцны 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байр		1.4	I-IV улиралд	НХБХГ
9	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо	Монголын үйлдвэрчний эвлэлийн Төв зөвлөлийн ажилчдын байр		0.31	I-IV улиралд	НХБХГ
10	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо	Номын худалдааны ажилчдын байр		0.11	I-IV улиралд	НХБХГ
11	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо	Улсын их дэлгүүрийн ажилчдын байр		0.28	I-IV улиралд	НХБХГ
		Дүн		4.68		

ДӨРӨВ. НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

4.1 Он дамжин хэрэгжиж буй ажил							
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбар тоо	Газрын хэмжээ /м2/	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо	Замын цагдаагийн уулзварын олон түвшний огтлолцол бүхий зам	1	500	Олон төвшний огтлолцол	2021-2023	НГЗБА, НАЗХГ
2	Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо	Хангайн 18,19, 20 дугаар гудамж	4	1633	Сургууль	2021	НГЗБА, НБГ, НХОГ
3	Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо	Хандгайтын 13, 14, 33, 34, 35 дугаар гудамж	16	12000	Эко орон сууцны хороолол	2021-2022	НГЗБА, БОАЖЯ
4	Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо	Санзайн 2,6 км авто зам	18	207	Авто зам	2021-2023	НГЗБА, НХБХГ, НАЗХГ
5	Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороо	Сэлбэ дэд төв	-	156000	Авто зам, шугам	2021	НГЗБА, НХОГ, АХБ

					сүлжээ		
6	Сүхбаатар дүүргийн 15, 16 дугаар хороо	Авто зам, гүүрийн ажил 1,8 км Дамбадаржаа 2-3, 13, 20-23 дугаар гудамж, Бэлх 6-7 гудамж	99	2658	Авто зам	2021-2023	НГЗБА, НХБХГ, НАЗХГ
7	Сүхбаатар дүүргийн 16, 17 дугаар хороо	Дамбадаржаа дэд төв	-	600000	Авто зам, шугам сүлжээ	2021-2023	НГЗБА, НХОГ, АХБ
8	Сүхбаатар дүүргийн 9, 11 дүгээр хороо	Алтайн 10, 11, Чингэлтэй 14,15, Нуурын 7 дугаар гудамж	69	26633	Үндэсний урлагийн их театр	2021	НГЗБА, НХБХГ
ДҮН			285	800591			

4.2 Барилга байгууламжийн газрыг чөлөөлөх							
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбарын тоо	Чөлөөлөх газрын хэмжээ /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хороо	Сэлбэ дэд төв	90	6.4	Орлогод нийцсэн орон сууц	I-IV улиралд	НОСК, НГЗБА
2	Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо	Дендриологийн цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн урд талд	2	0.1	Эрүүл мэндийн төв	I-IV улиралд	НЭМГ, ТИКА, НГЗБА
3	Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо	Шарга морьт орчим	4	0.3	Хог боловсруулах үйлдвэрийн барилга	I-IV улиралд	ЗАА, НГЗБА
4	Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	1	0.027	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолборын барилга	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА
5	Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороо	Хорооны нутаг дэвсгэрт	26	960	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолборын барилга	2021	СБДЗДТГ, ДГЗБА
6	Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	3	0.12	Хүүхдийн цэцэрлэг	2021	СБДЗДТГ, ДГЗБА

7	Сүхбаатар дүүрэг 9, 11-р хороо	Хорооны нутаг дэвсгэрт	5	0.3	Соёлын төв	2021	СБДЗДТГ, ДГЗБА
8	Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12, 13, 14 дүгээр хороодын аль нэг нутаг дэвсгэрт	Хорооны нутаг дэвсгэрт	18	-	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга	2021	СБДЗДТГ, ДГЗБА
9	Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо	Хорооны нутаг дэвсгэрт	4	-	Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолборын барилга	2021	СБДЗДТГ, ДГЗБА
10	Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хороо	Хороодын нутаг дэвсгэрт	30	-	Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд	2021	СБДЗДТГ, ДГЗБА
Дүн			200	97.92			

4.3 Авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн газрыг чөлөөлөх

Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбар тоо	Чөлөөлөх газрын хэмжээ /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо	Рашааны 9, 10 дугаар гудамжинд хийгдсэн авто замыг үргэлжлүүлэх /4 айлын газрыг 2м татуулах/	4	0.224	I-IV улиралд	СБДЗДТГ, ДГЗБА	Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо
Нийт			4	0.224			

ТАВ. ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Газрын төлбөрийн орлого бүрдүүлэх чиглэлээр

Д/д	Дүүрэг	Зориулалт /нэгж талбар бүрийг зориулалтаар нь ангилна/	Газрын хэмжээ /м^2/	1м^2 газарт ногдуулах төлбөрийн хэмжээ	Татвар тооцох хугацаа	Нийт төвлөрүүлэх төлбөрийн хэмжээ	Биелэлт

				/төг/		/мян.төг/	
1	Сүхбаатар дүүрэг	Иргэний ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газар 4077	107723	33	Жилдээ	22045.40	Дүүргийн татварын хэлтэс
2		Төсөвт байгууллага 829	17960	141		1131.14	
3		Нийтийн зориулалттай орон сууц 1407	1332117	174		324856.0	
4		Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ 10216	1206633	358		488033.14	
5		Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц 311	3261	358		3699.80	
6		Бүх төрлийн гарааш /газар дээрх, доорх/ 128	0	0		0	
7		Нийтийн эдэлбэрийн газар 28	0	0		0	
8		Инженерийн шугам сүлжээ түүний дэд бүтэц байгууламж 276	1663	70		264.88	
9		Төмөр зам, нисэх онгоцны буудал 13	0	0		0	
10		Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар 19	0	0	Жилдээ	0	
11		Шашин, сүм, хийд 101	19099	476		11203.24	
12		Химийн хорт бодис арьс шир ноос ноолуурын үйлдвэр, цэвэрлэх байгууламж болон аюултай хог хаягдлын үйлдвэр 10	0	0		0	
13		Бүх төрлийн үйлдвэрлэл /хөдөө аж ахуйгаас бусад/ 1821	81362	1152		23069.39	
14		Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 1947	510303	32		25697.01	
15		Уурхайн эдэлбэр газар	-	-		0	

16		Хөдөө аж ахуйн газар /тариалан, хадлан, бэлчээр/ 98	0	0		0	
17		Бусдаас /Сангийн яамнаас гаргасан төсвийн төлөвлөгөөний зөрүү/	-	-		0	
Нийт			3280121			900000.0	

--o0o--